



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ГАРГАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Паркийн өргөтгөл 130 га газрын кадастрын хэмжилт, зураглалын ажлыг “Хишигт Хөндий” ХХК-аар гүйцэтгүүлсүгэй.
2. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц хариуцсан инженер /Г.Пүрэвдорж/-д даалгасугай.
3. Дээрх зардалд 5,183,000 /таван сая нэг зуун наян гурван мянга/ төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.



С.БАТЖАРГАЛ